ОРШИЛ

“Инфинити Спэйс” ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших “Баянголын төмрийн хүдрийн ордын төв хэсгийн зүүн биетийг ашиглах” төсөл нь MV-016947, MV-022128 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 816.35 гектар талбайд үйл ажиллагаагаа явуулж байна. Уг төсөл нь Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Засгийн газар, Байгаль орчны болон бусад холбогдох яамнаас гаргасан зохих заавар журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг /БОМТ/ төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчин болон хүмүүст нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийн эсрэг хэрэгжүүлсэн арга хэмжээ, урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээнүүд, нөхөн сэргээлт, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр /ОХШХ/ зэрэгт шаардлагатай зардал, тооцоо, мөрдөж ажиллах хууль тогтоомж стандартуудыг тусгалаа.

“Инфинити Спэйс ”ХХК нь Баянголын төмрийн хүдрийн ордын төв хэсгийн зүүн хойд үргэлжлэл дээр хайгуулын ажлын үр дүнгийн тайланг боловсруулан бичиж улмаар 2011 оны 7 дугаар сарын 8-нд боломжтой болон бодитой /В+С/ зэрэглэлээн 41818,972 мянган тонн хүдрийн нөөц АМГ-ын Геологи судалгааны хэлтэс, ЭБМЗ-р батлуулсан. 2022 оны 1 дүгээр сарын 6-нд АМГ-ын Геологи судалгааны хэлтэс, ЭБМЗ-ээр батлуулсан болно. Үүнээс жилд дунджаар 3.000.000 тн олборлохоор тооцоолоход 15 жил зарцуулагдахаар ТЭЗҮ-д тусгагдсан байна. Баянголын төмрийн ордод хийгдсэн хайгуулын ажлын үед олон жилийн цэвдэг илрээгүй нь ордыг ил аргаар олборлох таатай нөхцөлийг бүрдүүлж байна.

“Инфинити Спэйс ”ХХК-ний 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 дугаар журмын дагуу боловсруулав.

Ашигт Малтмал Газрын Тосны газраас “Инфинити Спэйс” ХХК-д Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт дахь “Хандгайт” нэртэй газарт орших 935.65 гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож MV-016947 дугаар бүхий гэрчилгээг 2011 оны 11 сарын 10-ний өдөр олгосон байна. 2014 оны 9-р сарын 12-нд 9019007019 тоот улсын бүртгэлийн дугаартай “Болд төмөр ерөө гол” ХХК-д 275.01 га хэсэгчлэн шилжүүлсэн 660.64 га талбай үлдсэн.

ЭБЭХЯ-ны дэргэдэх АМГТГ-ын Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2011 оны 07 сарын 08-ны өдрийн хурлын хуралдааны ХХ-13-01 дугаар дүгнэлтийг үндэслэн (Ордын нөөц 2011 оны 05-р дугаар сарын 25-ны байдлаар) Хандгайт нэртэй MV-016947 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд хамрагдах төмрийн хүдрийн бодитой болон боломжтой (B+C) нөөцийг 41818.97 мян.тн-оор, үүнээс бодитой (B) нөөцийг 32447.43 мян.тн-оор, боломжтой (C) нөөцийг 9371.54 тн-оор хүлээн авсан байна. 2022 оны 1 дүгээр сарын 6-нд АМГ-ын Геологи судалгааны хэлтэс, ЭБМЗ-ээр батлуулсан болно. Үүнээс жилд дунджаар 3.000.000 тн олборлохоор тооцоолоход 15 жил зарцуулагдахаар ТЭЗҮ-д тусгагдсан байна. Баянголын төмрийн ордод хийгдсэн хайгуулын ажлын үед олон жилийн цэвдэг илрээгүй нь ордыг ил аргаар олборлох таатай нөхцөлийг бүрдүүлж байна.

2024 оны уулын ажлын төлөвлөгөөнд заасан хөрс хуулалт, хүдэр олборлолтын хэмжээ болон гүйцэтгэлийг 2024 оны 10 сарын 25-ны байдлаар хүснэгт-1-т үзүүлэв.

*Хүснэгт- 1 Уулын ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэл*

| д/д | Үзүүлэлт | Улсын төлөвлөгөө | Гүйцэтгэл | % |
|---|---|---|---|---|
| 1 | Уулын цул мян.м3 | 7116.01 | 3076.319 | 43.2 |
| 2 | Хөрс хуулалт мян.м3 | 6405.47 | 2757.283 | 90.8 |
| 3 | Хүдэр олборлолт мян.тн | 3037.188 | 1196.388 | 39 |

**Дэд бүтэц, зам харилцаа:** Тус орд газар нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Баянгол болон Булаг голын бэлчир орчим Дархан хотоос зүүн хойш 120 км, Сүхбаатар хотоос зүүн урагш 200 км, Ерөө сумын төвөөс зүүн урагш 30 км, Бугант суурингаас баруун урагш 20 км-д байрлана.

Цахилгаан хангамжийн хувьд “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн шинээр тавьсан 110 квт-ын өндөр хүчдэлийн шугамаас 4 км, цахилгааны Баянгол дэд станцаас 3 км, Хандгайт дахь дэд станцаас 6 км зайд байрладаг. Мобикомын суурин антенн Баянголын ордоос баруун хойш 4.5 км-т байрлах ба гар утсаар чөлөөтэй холбогдоно. Дулаанхаан өртөөн дэх УБТЗ-ын Ерөө өртөөнөөс Баянголын төмрийн хүдрийн орд хүртэл “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн тавьсан 98 км төмөр замын төгсгөл болох шинээр баригдсан Хандгайт өртөөн дэхь төмрийн хүдэр ачиж буулгах хэсэг нь Баянголын ордоос хойшоо 8 км зайтай байрладаг.

**Төслийн хүчин чадал:** “Инфинити Спэйс” ХХК нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжих үйл ажиллагааны хүрээнд төмрийн хүдрийг олборлох, баяжуулах зорилгоор ордыг ашиглахаар төлөвлөсөн. Уг төслөөс Сэлэнгэ аймгийн Ерөө сумын бүс нутагт хэрэгжүүлэх “Баянголын төмрийн хүдрийн ордын төв хэсгийн зүүн биетийг ашиглах” төслийн хүрээнд 2011 оны 7 дугаар сарын 8-нд боломжтой болон бодитой /В+С/ зэрэглэлээн 41818,972 мянган тонн хүдрийн нөөц АМГ-ын Геологи судалгааны хэлтэс, ЭБМЗ-р батлуулсан. Үүнээс жилд 2.500.000 тн олборлохоор тооцоолоход 15 жил зарцуулагдахаар ТЭЗҮ-д тусгагдсан байна. 2022 оны 1 дүгээр сарын 6-нд АМГ-ын Геологи судалгааны хэлтэс, ЭБМЗ-ээр батлуулсан болно. Үүнээс жилд дунджаар 3.000.000 тн олборлохоор тооцоолоход 15 жил зарцуулагдахаар ТЭЗҮ-д тусгагдсан байна. Баянголын төмрийн ордод хийгдсэн хайгуулын ажлын үед олон жилийн цэвдэг илрээгүй нь ордыг ил аргаар олборлох таатай нөхцөлийг бүрдүүлж байна.

**Ил уурхайн үйл ажиллагааны тухай:** Уурхайн өдөр тутмын үйл ажиллагаа нь өрөмдлөг, тэсэлгээ, ухаж ачих, хөрс болон хүдэр тээвэрлэлт, овоолго гэсэн дэс дараатайгаар явагдана.

**Ажиллах хүчний тухай:** Тайлант онд нийт 258 хүн ажилласан.

**Уурхайд ажиллуулах техник тоног төхөөрөмж:** Баянголын ордын төв хэсгийн зүүн биетийн нөөцийг ил уурхайн аргаар олборлохоор төлөвлөсөн. Уурхайд ажиллуулах техник, тоног төхөөрөмжийн сонголтыг БНХАУ-н уул уурхайд өргөн хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмжүүдийг техникийн үзүүлэлт, үнэ, ашиглалтын гол зардал, хүчин чадал зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн сонгосон.

2024 онд Хандгайт уурхайд ажилласан техник тоног төхөөрөмжийн мэдээлэл

*Хүснэгт- 2 Уулын ажилд ашигласан техник*

| № | Техник Ашиглагдах тоног төхөөрөмж | Марк, багтаамж | Хэмжих нэгж | Нийт тоо | Ажиллаж байгаа | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Цахилгаан экскаватор | Komatsu PC-3000 | Ш | 1 | 1 | |
| 2 | Гидро экскаватор | Komatsu PC-1250 | Ш | 4 | 4 | |
| 3 | Гидро экскаватор | Volvo EC700L | Ш | 1 | 1 | |
| 4 | Автосамосвал | Komatsu HD-785 | Ш | 17 | 15 | 2-Зүүн олборлолтын албанд ажиллаж байгаа |
| 5 | Бульдозер | Komatsu | Ш | 2 | 2 | |
| 6 | Дугуйт түрэгч | Komatsu WD600 | Ш | 1 | 1 | |
| 7 | Ачигч | Volvo L220H | Ш | 1 | 1 | |
| 8 | Ачигч | Volvo L350F | Ш | 1 | 1 | |
| 9 | Усны машин | TEREX-50 | Ш | 1 | 1 | |
| 10 | Молдок | Kobelco SK330 | Ш | 1 | 1 | |
| 11 | Үйлчилгээний машин | land-77 | Ш | 1 | 1 | |
| 12 | Үйлчилгээний машин | land-100 | Ш | 1 | 1 | |
| 13 | Зорчигч тээвэр | | Ш | 1 | 1 | |
| 14 | Түлшний машин | | Ш | 1 | 1 | |
| | Нийт | | | | 34 | 32 |

## БҮЛЭГ ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт -3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээний гүйцэтгэл | Ажлын хэмжээ | Төлөвлөгөө /мян.төг/ | Гүйцэтгэл /мян.төг/ |
|---|---|---|---|---|
| **1. Агаар орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахаар авсан арга хэмжээ** | | | | |
| 1 | Агаарын тоосжилтын эх үүсвэрүүд болох ХБУ, тээврийн замд агаарын тоосжилтын Pm2.5 Pm10 хэмжилтийг Сэлэнгэ аймгийн УЦУОШГ-р 2 цэгээс 2 удаагийн давтамжтай шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээгээр стандартаас давсан үзүүлэлттэй гарсан тул цаашид тоосжилтын эх үүсвэр болох ХБУ дээр тоос баригчийн цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийлгэхээр төлөвлөгөө боловсруулан ажиллана. | Агаарын 4 цэгээс 2 удаа | ОХШХ-т тусган оруулав. | |
| 2 | Агаарын бохирдлын /$SO_2$, $NO_2$/шинжилгээг засварын талбай болон хотхоны уурын зуухнаас 2 удаагийн давтамжтай УЦУОШГ-р хийлгэж ажилласан бөгөөд стандартаас давсан үзүүлэлтгүй гарсан. | | | |
| 3 | Уурхайд ашиглагдаж байгаа нийт автотээврийн хэрэгсэл болон өөрөө явагч хэрэгсэлд агаар бохирдуулсаны төлбөрийг тооцож МТА-нд 360,000 төгрөгийн татвар төлж ажилласан. | Нийт 40 тээврийн авто хэрэгсэл | 1 000,0 | 360,0 |
| 4 | Уурхайн тоос хэмжилтийн хяналтын цэгийн тоог нэмэгдүүлэх, тодорхойлох ажлын хүрээнд Тээврийн зам болон Баянгол хотхонд Inf/Area 24/01, Inf/Area24/02 цэг нэмж тодорхойлон самбар хийж байршуулан координатыг мэдээллийн санд бүртгэсэн. | 2 ш самбар | ОХШХ тусгав | |
| 5 | Хандгайт уурхай нь карьер болон тээврийн зам, технологийн замын маршрутын дагуу тоосжилт дарах зориулалтаар 39-16 дугаартай тэрэкс машиныг усалгаа хийх зориулалтаар засч янзлан битүүлэн усалгааны машин болгон усалгааг тогтмол хийж ажилласан. Усны машины хуваарь гарган, бүртгэл болон усалгааны маршрутад хяналт тавин ажиллаж байна. | 15м өргөн 3,2 км урт зам | - | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ***2. Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээ*** | | | | |
| 6 | Хандгайт уурхай нь шимт хөрсний 3 овоолготой. Тайлант онд 13400м3 шимт хөрсийг нөхөн сэргээлтэнд эргүүлэн авч ашигласан. 2024 оны 10 сарын эцсийн байдлаар нийт 38592 м3 шимт хөрсний үлдэгдэлтэй байна. | Овоолго №1- 30303м3<br>Овоолго №4 – 3691м3<br>Овоолго №3 – 17998м3 | ҮАЗ | ҮАЗ |
| 7 | Авто тээврийн хэрэгсэлийг тогтсон маршрутаар зорчиход БО-ны инженерүүд машин техникийн GPS-д хяналт тавьж ажилладаг. Тайлант онд технелогийн замаас гарч эрүүл газарт газарт машин техникээ зогсоосон 1тохиолдлыг GPS-р илрүүлж мэдэгдэх хуудас өгч зөрчлийг арилгаж ажилласан. | Уурхайн хэмжээнд | ҮАЗ | ҮАЗ |
| 8 | Засварын талбай болон ХБҮ-н асгаралт үүсэх эрсдэлтэй ажлын байрны үзлэг хяналт шалгалтыг 7 хоногт 1 удаа Бямба гариг бүр хийж, Асгаралт үүсэх өндөр магадлалтай ХММЗ талбай болон Өрмийн засварын талбай, ХБҮ маслын станцын байранд саармагжуулах, шингээх бодисыг /үртэс, хужир/ бэлэн байдалд байршуулан ажилласан. Мөн ХММЗ талбайг бетонжуулж асгаралтаар хөрс ус бохирдохоос сэргийлж ажилласан. | 150м2 талбай<br>15 шуудай хужир<br>15 шуудай үртэс | 1.000.0 | 10.241.0 |
| 9 | Тайлант онд 22596 м3 шимт хөрсийг MNS 5914:2008 "Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт" стандартын дагуу хуулж шимт хөрсний овоолго үүсгэн хадгалж байна. Газрын өндөршилтөөс хамаарч шимт хөрсний зузаан харилцан адилгүй байна. | 22596 м3 шимт хөрс | ҮАЗ | ҮАЗ |
| ***3. Газрын доорхи болон гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээ*** | | | | |
| 10 | Хандгайт уурхайн ажилчдын амрах байр болон ажлын байрнуудад усны хэрэглээг багасгах, усыг гамтай хэрэглэх үр ашиггүй зарцуулалтыг багасгах зорилгоор ''Усаа хэмнэ'' уриатай зурагт постер байршуулан мэдээдэл өгч ажилласан. | 10 ш постер | ҮАЗ | ҮАЗ |
| 11 | Булгийн ундарга, урсац, ус цуглуулах талбайг нэмэгдүүлэх, цэнгэг байдлыг хамгаалах зорилгоор Булгийн голын эхийг | 370м урт хашаа | - | 6,932,138 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хашаажуулан, үерийн усаар хөрс нурах эвдэрч урсахаас сэргийлэн хайрга чулуугаар урсацыг тойруулан засаж янзлан хамгаалсан. | | | |
| 12 | Гүний ус буюу Баянгол хотхоны унд ахуйд ашиглагдаж буй худгийн усанд Сэлэнгэ аймгийн УЦУОШГазраар жилд 2 удаагийн давтамжтай химийн шинжилгээг шинжлүүлж ажилласан. | Баянгол хотхон худаг Жилд 2 удаа | ОХШХ тусгав | ОХШХ тусгав |
| 13 | Гүний усны мониторинг, түвшин хэмжилтийг сар бүрийн 15,30-ны өдөр хийж хяналт тавьж, мэдээллийн сан үүсгэн ажилладаг. 2024 онд нийт 12 удаагийн мониторинг хэмжилт хийж ажилласан. | Гүний 1 худаг Хяналтын 1 цооног | ҮАЗ | ҮАЗ |
| 14 | 2024 оны Ус ашиглуулах дүгнэлтийг ЗГ-н хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, Ус ашиглах гэрээ, зөвшөөрлийг ХЕГСГ-р тус тус гаргуулан төлбөр тооцоог төлж ажилласан. | 2024 оны Ус ашиглуулах дүгнэлт, Усны гэрээ, зөвшөөрөл | | |
| **4. *Ургамлан нөмрөг*** | | | | |
| 15 | Ургамлын мониторинг судалгааг Хандгайт уурхайн мониторингийн 2 цэгт ургамлын бүрхэц, зүйлийн бүрэлдэхүүн, ач холбогдлыг тодорхойлж мэдээллийн сан үүсгэн ажилласан. Мониторингийн цэгт нийт 27 зүйлийн ургамал бичигдсэн. | Мониторингийн 2 цэг | ҮАЗ | ҮАЗ |
| 16 | Олон наст ургамлын үрийн нөөц бүрдүүлэн биологийн нөхөн сэргээлтэд ашиглахаар ХБҮ-н гадна талбайд таригдсан согоовруын үр, ашиглалтын талбайгаас бэлчээрийн ургамал болох явган сорвоо, ерхөг, согоовор зэргийн үр түүсэн. Биологийн нөхөн сэргээлтийн туршилтаар шимт хөрсний 1-р овоолгыг ургамалжуулан биологийн нөхөн сэргээлт хийхэд ашигласан. Мөн өртөгдөх талбайгаас нарс модны боргоцой түүж бэлтгэсэн. | 1 шуудай 20 кг үр | 1.000.0 | 2.340.938 |
| **5. *Амьтан хамгаалал*** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 17 | Уурхайн бүсэд амьдарч буй ан амьтныг хөдөлгөөн мэдэрч зураг дарах камерын тусламжтайгаар амьтны тоо толгой зүйлийг тодорхойлж дүгнэлт гарган ажилласан. | 10 төрөл зүйлийн амьтад | ҮАЗ | ҮАЗ |
| 18 | Ан амьтанд биотехникийн арга хэмжээгээр амьд үлдэх, үр төлөө үлдээх нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд эхний ээлжинд зэрлэг уулын туруутан амьтдад зориулан уст цэг дагуу амьтадын жим дагуулан 10 боодол өвс, 10 ш ашигт долооцыг тараан байршуулж идэш тэжээлийг бэлтгэн ажилласан. | 10ш ашигт долооц<br>10 боодол өвс | ҮАЗ | ҮАЗ |
| 19 | 2024 онд Хандгайт уурхайн бүсэд цахилгааны шугам дагуу нийт 6 зүйлийн шувуу бүртгэгдсэн. Үүнээс алаг шаазгай өндөр хүчдэлийн тогонд цохиулан эндсэн тул цахилгааны шугамд шувуу үргээгч байрлуулсан. Шувуу үргээгчийг хуучирсан диск ашиглан хийсэн. | Өндөр хүчдэлийн 110 станцын шугамд | ҮАЗ | ҮАЗ |
| | **Нийт** | | **3000.0** | **19,874,076** |

# БҮЛЭГ ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## 2.1. Агаар орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахаар авсан арга хэмжээ:

2.1.1. Агаарын тоосжилтын эх үүсвэрүүдэд /нийт тоос, PM 2.5, PM10/ агаарын тоосжилтын хэмжилтийг хийлгэж ажилласан. ОХШХ тусгав.

2.1.2. Агаарын бохирдлын /$SO_2$, $NO_2$ /шинжилгээг жилд 2 удаа хийлгэж ажилласан. ОХШХ дэлгэрэнгүй тусгав.

2.1.3. Уурхайд ашиглагдаж байгаа нийт авто тээврийн хэрэгсэл болон өөрөө явагч хэрэгсэлд агаар бохирдуулсаны төлбөрийг тооцож МТА-нд 360,000 төгрөгийн татвар төлж ажилласан.

*Зураг 2.1 МТА төлөгдсөн агаар бохирдлын төлбөрийн жагсаалтууд*

| Нэхэмжлэхийн дугаар | Нэхэмжлэхийн төрөл | Татварын төрөл | Татварын алба | Татварын дэд алба | Дүн | Төлсөн огноо |
|---|---|---|---|---|---|---|
| 1240119608975 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 100,000.00 | 2024-02-07 07:04:00 |
| 1240119604578 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 14,000.00 | 2024-02-07 07:06:34 |
| 1240119606904 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 14,000.00 | 2024-02-07 07:08:14 |
| 1240116471328 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 100,000.00 | 2024-02-20 02:16:46 |
| 1240116420614 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 100,000.00 | 2024-02-20 02:19:02 |
| 1240116430126 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 100,000.00 | 2024-02-20 02:20:40 |
| 1240116446874 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 100,000.00 | 2024-02-20 02:25:22 |
| 1240116444812 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 100,000.00 | 2024-02-20 02:25:58 |
| 1240116430159 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 100,000.00 | 2024-02-20 02:29:36 |
| 1240116430134 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 100,000.00 | 2024-02-20 02:30:19 |
| 1240116430183 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 100,000.00 | 2024-02-20 02:31:04 |
| 1240116421091 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 100,000.00 | 2024-02-20 02:31:42 |
| 1240116421117 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 100,000.00 | 2024-02-20 02:32:20 |
| 1240116420606 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 100,000.00 | 2024-02-20 02:34:37 |
| 1240116387706 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 100,000.00 | 2024-02-20 02:36:13 |
| 1240116446866 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 100,000.00 | 2024-02-20 02:38:46 |
| 1240206944291 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сүхбаатар дүүрэг | Дүүргийн төвлөрсөн | 31,872.00 | 2024-02-20 02:44:26 |
| 1240601165906 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сүхбаатар дүүрэг | Дүүргийн төвлөрсөн | 440,000.00 | 2024-06-13 02:25:56 |
| 1240601166094 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сүхбаатар дүүрэг | Дүүргийн төвлөрсөн | 440,000.00 | 2024-06-13 02:26:39 |
| 1240602067994 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сүхбаатар дүүрэг | Дүүргийн төвлөрсөн | 550,000.00 | 2024-07-07 01:57:28 |
| 1240602067903 | Нэхэмжлэх | Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | Сүхбаатар дүүрэг | Дүүргийн төвлөрсөн | 550,000.00 | 2024-07-07 01:58:17 |
| 1240122406862 | Нэхэмжлэх | Автын агаарын бохирдлын төлбөр | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 9,500.00 | 2024-02-07 07:04:00 |
| 1240122397855 | Нэхэмжлэх | Автын агаарын бохирдлын төлбөр | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 9,500.00 | 2024-02-07 07:06:34 |
| [illegible] | Нэхэмжлэх | Автын агаарын бохирдлын төлбөр | Сэлэнгэ | Аймгийн төвлөрсөн | 9,500.00 | 2024-02-07 07:08:14 |

2.1.4 Уурхайн тоос хэмжилтийн хяналтын цэгийн тоог нэмэгдүүлэх, тодорхойлох ажлын хүрээнд Тээврийн зам болон Баянгол хотхонд IS/Area 24/01, IS/Area24/02 цэг нэмж тодорхойлон самбар хийж байршуулсан.

*Зураг 2.2 Тоос хэмжилтийн 2 цэгийн зураг*



Хандгайт уурхай нь карьер болон тээврийн зам, технологийн замыг маршрутын дагуу тоосжилт дарах зориулалтаар 39-16 дугаартай trx машиныг усалгаа хийх зориулалтаар засаж янзлан битүүлж, усалгааны машин болгон усалгааг тогтмол хийж ажилласан. Усны машины хуваарь гарган, усалгааны маршрутанд хяналт тавин ажиллаж байна.

*Зураг 2.3- Усны машины усалгаа хийх замын маршрут, хуваарь*



*Зураг 2.4: Усны машины усалгаа хийж байгаа явц*



## 2.2. Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээ

2.2.1. Хандгайт уурхай нь шимт хөрсний 3 овоолгод шимт хөрсийг нөөцлөн салхинд хийсч элэгдэхээс хамгаалж овоолго үүсгэн шууж хэлбэршүүлэн стандартын дагуу хадгалж байна. Овоолго №1 дээр 30303м3, овоолго №4 – 3691м3, овоолго №3 – 17998 м3 хөрс байна. Үүнээс тайлант онд 13400м3 м3 шимт хөрсийг нөхөн сэргээлтэд эргүүлэн авч ашигласан. 2024 оны 10 сарын эцсийн байдлаар нийт 38592 м3 шимт хөрсний үлдэгдэлтэй байна.




*Зураг 2.5: Шимт хөрсийг шууж хэлбэршүүлэн хадгалсан овоолгын болон байршилын зураг*





*Зураг 2.6: Нөхөн сэргээлтэнд авч ашигласан явц*





2.2.2. Авто тээврийн хэрэгслийг тогтсон маршрутаар зорчих, салаа зам гаргахаас сэргийлж БО-ны инженерүүд машин техникийн GPS-д хяналт тавьж ажилладаг. Тайлант онд технелогийн замаас гарч эрүүл газарт машин техникээ зогсоосон тохиолдолыг GPS-р илрүүлж мэдэгдэх хуудас өгч зөрчлийг арилгаж ажилласан.

*Зураг 2.7 Салаа зам гаргасан зөрчилийн мэдэгдэх хуудас GPS-н байршил*



2.2.3. Засварын талбай болон ХБҮ-н асгаралт үүсэх эрсдэлтэй ажлын байрны үзлэг хяналт шалгалтыг 7 хоногт 1 удаа Бямба гариг бүр хийж, Асгаралт үүсэх өндөр магадлалтай ХММЗ талбай болон Өрмийн засварын талбай, ХБҮ маслын станцын байранд саармагжуулах, шингээх бодисыг /үртэс, хужир/ бэлэн байдалд байршуулан ажилласан. Хөрс ус бохирдохоос сэргийлж ХММЗ талбай, тос масло түр хадгалах агуулах болон ажилласан маслотой поошиг тавих талбайг бетонжуулан ажилласан.

*Зураг 2.8: Техникийн засварын бетонжуулсан талбайн зураг*





ЗАХИРГААНЫ ХЭЛТЭС "ЭДИЙН ЗАСАГ"

2024 оны 06-р сарын 16

Засварын талбайн зардлын тооцоо

Хүснэгт 1: Үндсэн үзүүлэлт

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Урт | м | 10 |
| 2 | Өргөн | м | 15 |
| 3 | Өндөр | см | 20 |
| 4 | Талбай | м2 | 150 |
| 5 | Бетоны хэмжээ | м3 | 31 |

Хүснэгт 2: Зардлын дүн /төг/

| № | Зардлын төрөл | Ажиллах цаг | Мөнгөн дүн /төг/ |
|---|---|---|---|
| 1 | Цалингийн зардал | 1 | 19,420 |
| 2 | Техникийн зардал | 1 | 146,448 |
| 3 | Бетоны зардал | | 9,143,000 |
| 4 | Бусад зардал | | 931,087 |
| | Нийт | | 10,241,955 |

Тайлбар: Хандгайт уурхайн засварын 150м2 талбайг бетонжуулах зардлын тооцоог тооцож гаргав.

Тооцоо: Эдийн засагч ........................ Р.[illegible]

*Зураг 2.9: Тос масло түр агуулах болон тос масло түр цуглуулах цэгийн бетонжуулсан талбай*



*Зураг 2.10: Саармагжуулах хужир байршуулж үртэс дэвссэн зураг*



2.2.4. Уурхайн ахилт орох талбайн шимт хөрсийг хуулж уулын ажил эхэлнэ. Хуулах шимт хөрсний хэмжээг төлөвлөлтийн инженерийн гаргасан төлөвлөгөөгөөр ГХЗөвшөөрөл хүсч, маягтын дагуу хөрсний бичиглэл хийж хуулах зузаан болон шимт хөрсний хэмжээг тооцно. Тайлант онд 22596 м3  шимт хөрсийг MNS 5914:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” стандартын дагуу хуулж шимт хөрсний овоолгод нийлүүлэн хадгалж байна. Газрын өндөршилтөөс хамаарч шимт хөрсний зузаан харилцан адилгүй байна.

*Зураг 2.11: Шимт хөрс хуулах зузааныг тогтоож хөрсний бичиглэл хийж байгаа явц*



*Зураг 2.12: Шимт хөрсний овоолгын зураг, хөрс хуулалтын явц*




## 2.3.Газрын доорхи болон гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээ

2.3.1. Хандгайт уурхайн ажилчдын амрах байр болон ажлын байруудад усны хэрэглээг багасгах, усыг гамтай хэрэглэх үр ашиггүй зарцуулалтыг багасгах зорилгоор Баянгол хотхоны байрууд болон гал тогоо, угаалгын газруудад ‘’Усаа хэмнэе’’ зурагт постер нийт-10 ш байршуулан ажилласан.

*Зураг 2.13 Постерыг Баянгол хотхон болон гал тогоонд байршуулсан.*



2.3.2. Булгийн ундарга, урсац, ус цуглуулах талбайг нэмэгдүүлэх, цэнгэг байдлыг хамгаалах зорилгоор Булгийн голын эхийг хашаажуулан, үерийн усаар хөрс нурах эвдэрч урсахаас сэргийлэн хайрга чулуугаар урсацыг тойруулан засч янзлан хамгаалсан. 2024 оны 04 сард голын хамгаалалтын бүст таригдсан бургасны амьдралтыг тодорхойлж нөхөн тарилт хийх шаардлагатай 2000ш бургасыг 2024 оны намрын мод тарих өдөр /09 сарын 20-10 сарын 20/ нөхөн тарьсан. Бургасыг байгалийн бүс бүслүүр харгалзахгүйгээр эгнээ хооронд 2м зайтай 30см гүнтэй тогоолон MNS 5918:2023 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага” стандартыг мөрдлөг технелогийн дагуу тарьсан.

*Зураг 2.14: Булгийн голын хамгаалалтын бүс дагуу бургас тарих явц*



*Зураг 2.15: Булгийн эхийг хашаажуулан эвдэрсэн хөрсийг хайрга чулуугаар засч янзалсан байдал*



*Зураг 2.16: Хашаажуулсан ажлын зардлын задаргаа*

Хүснэгт 1. Цалингийн зардал /төг/

| № | Ажилчдын нэрс | Ажилласан цаг | Цалингийн зардал /төг/ |
|---|---|---|---|
| 1 | Дамдинсүрэн Батжаргал | 36 | 786,504 |
| 2 | Батболд Чимэдцэрэн | 36 | 786,504 |
| 3 | Кадырбек Эржан | 36 | 612,747 |
| 4 | Алтангэрэл Төмөрхуяг | 36 | 971,753 |
| 5 | Баттүшиг Ганганцэг | 36 | 786,504 |
| 6 | Намсүх Батболд | 36 | 786,504 |
| 7 | С.Амарсайхан | 36 | 786,504 |
| 8 | Б.Бат-Очир | 36 | 786,504 |
| | **Нийт цалин** | **288** | **6,303,523** |

Хүснэгт 2. Сэлбэг материалын зардал /төг/

| № | Сэлбэгийн нэр | Хэмжээ | Нэгжийн үнэ /төг/ | Нийт үнэ /төг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Бэхлий | 30 | 1,058 | 31,733 |
| 2 | Будаг | 40 | 11,000 | 22,000 |
| 3 | Жижиг багс | 3 | 2,121 | 6,364 |
| 4 | Жижиг өнхрүүш | 3 | 1,650 | 4,950 |
| 5 | Будаг шингэлэгч | 6 | 4,981 | 29,884 |
| 6 | Троссон зүлгүүр | 2 | 3,701 | 7,401 |
| 7 | Тасдагч ир | 3 | 1,927 | 5,782 |
| 8 | Хөрс усны шинжилгээний төлбөр | | | 520,500 |
| | **Нийт** | | | **628,614** |

| | |
|---|---|
| **НИЙТ ЗАРДЛЫН ДҮН** | **6,932,138** |

*2.3.3.* Гүний ус буюу Баянгол хотхоны унд ахуйд ашиглагдаж буй худгийн усыг Сэлэнгэ аймгийн УЦУОШГазраар жилд 2 удаагийн давтамжтай шинжлүүлж ажилласан. Унд ахуйн усанд гол ион, биогений элемэнтийн шинжилгээ хийхэд MNS стандарт дахь ЗДХ-с даваагүй. /ОХШХ тусган оруулав./

*2.3.4.* Хандгайт уурхайд хамаарах Баянгол хотхоны гүний 1 худаг, хяналтын 1 цооногийн түвшин хэмжилт, тоолуурын заалтын бичиглэлийг сар бүрийн 15,30-ны өдөр тогтмол хэмжиж мэдээллийн сан үүсгэн ажилласан.

*Зураг 2.17: Баталгаажсан тоолуурын гэрчилгээ, тоолуур, гүний усны түвшин хэмжих багаж*




*Зураг 2.18: 2023,2024 оны усны хэрэглээ, гүний усны хэмжилтийг графикаар харьцуулав*



2024 онд гүний худагт нийт 12 удаагийн мониторинг хэмжилтийг хийсэн. Гүний усны түвшин, худгийн тоолуурын бичиглэлийг өмнөх онтой харьцуулан үзэхэд 2024 онд унд ахуйд өмнөх оныхоос бага ус ашигласан нь графикаас харагдаж байна. Мөн усны хэрэглээ багасхад гүний усны түвшин 2024 онд нэмэгдсэн харагдаж байна. Баянгол хотхоны шинэ худагт LXLC 65 загварын хүйтэн усны тоолуур суурилуулан стандарт хэмжил зүйн газраар 2024 оны 04.10-нд баталгаажуулсан. Хяналтын цооногийн хэмжилтийг Levilmetr багажаар 7 хоног бүр хэмжиж гүний усны түвшинд хяналт тавин ажилласан.

2.3.5. 2024 оны Ус ашиглуулах дүгнэлтийг ЗГ-н хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, Ус ашиглах гэрээ, зөвшөөрлийг ХЕГСГ-р тус тус гаргуулан усны төлбөр тооцоог барагдуулж ажилласан.

*Зураг 2.19: Усны гэрээ, зөвшөөрөл, дүгнэлт, төлбөрийн баримт*







УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2024 оны 8 дугаар сарын 29 -ний өдөр

Дугаар Е-2407-000081

Улаанбаатар хот

Утас: 265528, 265578

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Оноосон нэр: Инфинитиспэйс

Улсын бүртгэлийн дугаар:

Регистрийн дугаар: 5467268

Захирал: Билэгсайхан

Холбоо барих дугаар: 99997707

Факс:

И-мэйл хаяг:

2. Төслийн нэр байршил

Төслийн нэр:

Байршил:

Харьяалагдах сав газар:

Хамаарах салбар: Уул уурхай

3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

Инфинитиспэйс

4. Ажиллах горим, хүчин чадал

| Үргэлжлэх хугацаа | Ажиллах горим | Жилд ажиллах хоног | Хоногт ажиллах ажилчдын тоо | Хоногт ажиллах цаг |
|---|---|---|---|---|
| 15 | 2 ээлжээр | 306 | 242 | 24 |

5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

| Ажлын нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тайлбар |
|---|---|---|---|
| Зам талбайн усалгаа | 82500.0 | м2 | [illegible] |
| [illegible] | 554.0 | [illegible] | [illegible] |



ГОЛОМТ БАНК

## 2.4 Ургамлан нөмрөг

2.4.1 Хандгайт уурхайн ургамлын мониторингийн 2 цэгт раменсекийн торон аргаар ургамлын тусгаг бүрхэц, өсөлт, статус, зүйлийн бүрэлдэхүүн, ач холбогдол болон ховор ургамлыг тодорхойлж мэдээллийн сан үүсгэн ажилласан.

*Зураг 2.20: Ургамлын мониторингийн цэгт бичиглэл хийж байгаа нь*




*Зураг 2.21: Нийт ургамлын зүйлийн бүрэлдэхүүн*

| | Шинжлэх ухааны нэр | Ургамлын монгол нэр | Овог | Экологийн бүлэг | Бүлгэмдлийн хэвшинж | Статус |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | *Fragaria orientalis* | Дорнодын гүзээлзгэнэ | Сарнайн овог | Мезофит | Ойн | Элбэг |
| 2 | Carex duriscula | Ширэг улалж | Улалжийн овог | Мезоксерофит | Нугын | - |
| 3 | *Phlomis tuberosa* | Булцуут түйпланцар | Уруул цэцэгтний овог | Мезофит | Нугын | - |
| 4 | Potentilla tanacetifolia | Марал навчит гичгэнэ | Сарнайн овог | Мезоксерофит | Нуга-хээрийн | - |
| 5 | Thalictrum minus | Бага бурхагар | Холтсоншэргийн овог | Мезофит | Нугын | - |
| 6 | Leymus chinensis | Хиаг | Үетний овог | Мезоксерофит | Нугын | - |
| 7 | Allium victorialis | Халиар | Сонгинын овог | Мезофит | Ойн | Хүнсний, ховор |
| 8 | Bromus inermis | Соргүй согоовор | Үетний овог | Мезофит | Нугын | - |
| 9 | Papaver nudicaule | Нүцгэн намуун | Намуутайн овог | Ксеромезофит | Нуга-хээрийн | - |
| 10 | Taraxacum officinale | Эмийн багваахай | Гэсэрцэцэгтний овог | Мезофит | Нугын | Элбэг |
| 11 | Carum buriaticum | Буриад Гоньд | Шүхэртний овог | Мезоксерофит | Уулын хээрийн | Элбэг |
| 12 | Potentilla acaulis | Ишгүй гичгэнэ | Сарнайн овог | | | - |
| 13 | Chenopodium acuminatum | Шоргор лууль | Луулийн овог | Мезоксерофит | Космополит | - |
| 14 | Potebtilla bifurca | Ишт гичгэнэ | Сарнайн овог | Мезофит | Космополит | Элбэг |
| 15 | Urtica cannabina | Олсны халгай | Халгайн овог | Мезоксерофит | Космополит | Эмийн, элбэг |
| 16 | Achillea asiatica | Азийн толгой өвс | Гэсэрцэцэгтний овог | Мезофит | Нугын | Ховор, эмийн |
| 17 | Geranium pratense | Нугын шимтэглэй | Шимтэглэйн овог | Мезофит | Нугын | Цайны |
| 18 | Anemone crinita | Сэгсгэр яргуйхан | Холтсоншэргийн овог | Мезофит | Нугын | |
| 19 | Oxytropis myriophylla | Түмэннавчинцарт Ортууз | Буурцагтны овог | Галомезофит | Нугын | Салбар ургаган |
| 20 | Rosa acicularis | Өргөст нохойн хошуу | Сарнайн овог | Мезофит | Ойн | Эм, хүнс, элбэг, чимэглэл |
| 21 | Vicia cracca | Хулганын гиш | Буурцагтны овог | Мезофит | Нугын | - |
| 22 | Agrimonia pilosa | Үслэг ловго | Сарнайн овог | Мезофит | Нугын | - |
| 23 | Medicago falcata | Хадуурган Царгас | Буурцагтны овог | Мезофит | Нугын | - |
| 24 | Descurainia sophia | Софийн борбут | Загалмайн цэцгийн овог | | | |
| 25 | Dracocephalum foetidum | Үмхий Шимэлдэг | Уруул цэцэгтний овог | Ксерофит | Хээрийн | Элбэг |
| 26 | Artemisia dracunculus | Итгэн шарилж | Гэсэрцэцэгтний овог | Ксеромезофит | Хээрийн | - |
| 27 | Lilium pumilum | Одой Сараана | Сараана овог | Мезофит | Нугын | - |

Төслийн талбай нь монгол орны ойн ургамалжилтын мужлалаар Өвөр байгалийн мужийн Баруун хойд Хэнтийн хошуунд хамаарна. Зонхилон ургасан нарс, хус, улиангаран ой нь д.т.д 940 – 1000метрт ургасан бөгөөд үетэн алаг өвст шинжтэй. Үетэн-алаг өвст ойн дээд зах Үетэн-сөөгөн боролжит Ерхөг-хялгана-зүр өвс-тавилганат уулын хээрийн бүлгэмдэл зонхилон ургасан. 15 овгийн 27 зүйлийн ургамал бүртгэгдсэн. Экологийн бүлгийн хувьд мезофит буюу чийгсэг бүлгийн ургамал зонхилон ургасан. Энэ нь богино хугацааны ганг тэсвэрлэж чаддаг ургамалд хамаарна. Уурхайн ажилтануудад ургамлын ач тус, зүйлийн нэршлийг таниулах зорилгоор уурхайн бүсэд ургаж буй цэцэгт ургамлуудаар ургамлын хатаамал хийж үзэсгэлэн гаргасан.

*Зураг 2.22: Ургамлыг овог, зүйлийн бүрэлдэхүүний хэв шинж, экологийн бүлгээр нь авч үзсэн*




*Зураг 2.23: 30 зүйлийн цэцэгт ургамлуудаар гербар хийсэн зураг*



2.4.2 Олон наст ургамлын үрийн нөөц бүрдүүлэн биологийн нөхөн сэргээлтэд ашиглахаар ХБҮ-н гадна талбайд таригдсан согооврын үр, ашиглалтын талбайгаас бэлчээрийн ургамал явган сорвоо, ерхөг, согооврын үр түүж шимт хөрсний овоолгыг ургамалжуулан биологийн нөхөн сэргээлтэнд ашигласан. 2024 оны 8.13-8.15 ны хугацаанд шуудай 20 кг үр түүсэн. Мөн уурхайн олборлолтод өртөгдөх талбайгаас нарс модны боргоцой 1 шуудайг түүж бэлтгэсэн.

*Хүснэгт 4 Ургамлын үр түүсэн зардлын тооцоо*

| № | Ажилласан хүн | 1 хүний өдөрт ажилласан цаг | Нийт ажилласан цаг | Нийт ажилласан өдөр | Нийт цалингийн зардал |
|---|---|---|---|---|---|
| 1 | 5 | 11 | 165 | 3 | 2.340.938 |

*Зураг 2.24: Ургамлын үр түүж байгаа зураг*



## 2.5 Амьтан хамгаалал

2.5.1 Уурхайн бүсэд амьдарч буй ан амьтныг хөдөлгөөн мэдэрч зураг дарах камерийн тусламжтайгаар болон нүдээр харж бичлэг, фото зургаар дүрсжүүлэн баримтжуулан дата мэдээлэл цуглуулсан. 2024 онд амьтны мониторинг судалгаагаар 10 төрлийн амьтан бүртгэгдсэн.

*Хүснэгт – 5: Хандгайт уурхайд бүртгэгдсэн амьтад*

| № | Камерт үзэгдсэн огноо | Тоо толгой | Зүйлийн монгол нэр | Латин нэр | Бүртгэгдсэн байршил | Амьтны статус |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 6/13/2024 | 1 | Шилүүс | Felis lynx | Булгийн гол болон хажуугийн уул | CITES |
| 2 | 6/15/2024 | 2 | Бор гөрөөс | Capreolos pygargus | Инфинити 1-р биетийн хажуу уул | |
| 3 | 7/15/2024 | 1 | Хүрэн баавгай | Ursus arctos | Инфинити 2-р биет хайгуулын замын ойролцоо | Ховор |
| 4 | 7/20/2024 | 1 | Халздай дорго | Meles meles | Инфинити Булгийн голын эсрэг талын уул | |
| 5 | 7/31/2024 | 5 | Саарал чоно | Canis lupus | Булгийн гол дагуу | CITES |
| 6 | 8/24/2024 | 3 | Зэрлэг гахай | Sus scrofa | Инфинити тээврийн замын хажуу Булгийн гол талдаа | Эмзэг |
| 7 | 8/29/2024 | 1 | Нөмрөг тас | Aegypius monachus | Хандгайт айлуудын зуслан орчим | ХБ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | 9/15/2024 | 7 | Дагуур ятуу | Perdix dauurica | Инфинити 1-н зам дагуу | |
| 9 | 10/12/2024 | 1 | Халиун буга | Cervus elaphus | Инфинити 1-р биет замын хажуу хусан ойд | Эмзэг |
| 10 | 10/12/2024 | 1 | Шар үнэг | Vulpes vulpe | Тоосгоны хажууд | |

*Зураг 2.25: Бүртгэгдсэн амьтадын төрөл зүйл*



2.5.2 Ан амьтдад биотехникийн арга хэмжээгээр амьд үлдэх, үр төлөө үлдээх нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд эхний ээлжинд зэрлэг уулын туруутан амьтдад зориулан уст цэг дагуу амьтадын жим дагуулан 10 боодол өвс, 10 ш ашигт долоодосыг тараан байршуулж идэш тэжээлийг бэлтгэн ажилласан.

*Зураг 2.26 Амьтны камер байршуулсан цэгийн зураг*



*Зураг 2.27 Ашигт долооц болон усны зүмп байгуулсан цэгт өвс байршуулсан зураг*



**Дүгнэлт:** Хүснэгтээс харахад Хандгайт уурхайд 10 төрөл зүйлийн амьтад амьдарч байна. Энэ бүс нутагт халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай зэрэг тураг ан амьтад байгааг тэдгээрийн ул мөр фото зураг, мөрөөр, түүнчлэн том махчин амьтдаас хүрэн баавгай, саарал чоно, үнэг, дорго зэрэг амьтад байгааг тэдгээрийн ул мөр, ялгадас зэрэгт болон өөрсдийн харсан, бичлэг зурагт мэдээ болон камерт үндэслэн тогтоов. Уурхайн лицензийн талбайн булаг чийглэг амьдрах орчинд амьтад ихээр бүртгэгдэх нь тухайн ус намгархаг амьдрах орчны төлөв байдал одоогоор хэвийн байгааг илтгэж байна. Мөн цаг агаарын хүндхэн нөхцөлөөс болж туруутан амьтдын идэш тэжээл хомсдох, тоо толгой буурахаас сэргийлж амьтдын жим дагуулж өвс, ашигт долооцыг тарааж байршуулсан. Ашиглалтын үед эдгээр амьтад үргэн дайжиж, байршлаа өөрчлөх тохиолдол гарч болзошгүй тул цаашид мониториг ажиглалтыг тогтмол хийж ажиллана.

2.5.3 2024 онд Хандгайт уурхайн бүсэд цахилгааны шугам дагуу нийт 6 зүйлийн шувуу бүртгэгдсэн. Цахилгааны шугам дагуу шувууны өртөлтийн судалгааг хийхэд суурин амьдардаг шувууд ихэнхдээ суурин газрын цахилгаан шугам дагуу бүртгэгдсэн. Суурин гэдэг нь тухайн нутагт жилийн аль ч улиралд амьдардаг, үрждэг, нүүдэллэдэггүй шувуудыг хамруулан авч үздэг. 2024 онд 1 алаг шаазгай 110 станцын цахилгааны шугамд өртсөн тул хуучин дискийг ашиглан шувуу үргээгч байрлуулсан.

*Зураг 2.28 Цахилгааны шугам дагуу бүртгэгдсэн амьтад*





*Зураг 2.29 Уурхайн бүсэд суурин амьдардаг шувууд*





*Хүснэгт –6 өндөр хүчдэлийн шугам дагуу бүртгэгдсэн болон эндсэн шувуудын судалгаа*

| № | Бүртгэгдсэн шувуудын нэр | | Өртөж эндсэн судалгаа | Өртсөн шувууны тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Алаг шаазгай | Pica pica | 1 | 1 |
| 2 | Хон хэрээ | Corvus corax | - | |
| 3 | Сүүлт хөхбух | Aegithalos caudatus | - | |
| 4 | Амарын шонхор | Falco amurensis | - | |
| 5 | Нөмрөг тас | Aegypius monachus | - | |
| 6 | Ятга шаазгай | Garrulus glandarius | | |

## БҮЛЭГ ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хандгайт уурхай нь 2024 онд нийт 16,6 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага'', MNS 5918:2023

"Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага" стандартыг тус тус баримтлан хийж гүйцэтгэсэн. Нийт 316,042,743 мянган төгрөгийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтэд зарцуулсан.

*Хүснэгт – 7: 2024 онд Нөхөн сэргээлт хийсэн зардал болон бусад мэдээлэл*

| № | Нөхөн сэргээлт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Ажлын хэмжээ | Төлөвлөгөө /мян.төг/ | Гүйцэтгэл /мян.төг/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Техникийн нөхөн сэргээлт | Хандгайт уурхай нь 2024 онд хуучин тээврийн замд ашиглагдаж байсан талбайд MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага" стандартын дагуу техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. | 6,7 га | 30,000.0 | 279,244.200 |
| 2 | Биологийн нөхөн сэргээлт | 2023 онд хийгдсэн техникийн нөхөн сэргээлтийн үе шат бүрэн дуусч талбайн хөрс чулуулаг тогтворжиж, нягтаршсаны дараа 2024 онд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг 6,4 га талбай дээр MNS 5918:2023 "Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага" стандартыг мөрдлөг болгон бургас тарилтыг хийж гүйцэтгэсэн. | 6.4 га | 24.000.0 | 36,798.543 |
| 3 | Биологийн нөхөн сэргээлт | Хандгайт уурхай нь шимт хөрсний 1-р овоолгыг салхинд хийсэх, хур борооны усанд урсах, элэгдэхээс сэргийлэн, хөрсний шимт чанарыг нэмэгдүүлэх зорилгоор ''Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага '' MNS 5918: 2023 стандартыг баримтлан олон наст үет ургамлын үрээр ургамалжуулан биологийн нөхөн сэргээлт хийсэн. | 3,5 га | УАЗ | УАЗ |
| | **Нийт** | | | **54.000.0** | **316,042,743** |

## 3.1 ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН БИЕЛЭЛТ – 6,7 га

Хандгайт уурхай нь 2024 онд хуучин тээврийн замаар ашиглагдаж байсан талбайд MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага" стандартын дагуу техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус талбай нь уулын ой, тайгын бүс бүслүүрт хамаарагдах ойн бараан хөрсний хэв шинжтэй бөгөөд 22 см зузаантай шимт хөрсөөр хучилт хийж экскаватор, ачигч, бульдозер, автосмасвал техникүүдээр ачиж хутган, шидэлт хийж хэлбэржүүлэн 13557 м3 үржил шимт хөрс, 63881м3 уулын цул хөндөн 23 хоногийн хугацаанд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

*Зураг 3.1: Техникийн нөхөн сэргээлт хийгдэхийн өмнө ба дараа*



*Зураг 3.2: Техникийн нөхөн сэргээлт хийгдэхийн өмнө ба дараа*



*Зураг 3.3 Нөхөн сэргээлтийн дэвсгэр зураг, газарзүйн зураг*





*Хүснэгт 8: 6.7 га талбайд хийгдсэн техникийн нөхөн сэргээлтийн зардлын задаргаа*

Хүснэгт 1. Зардлын задаргаа

| | Үзүүлэлт | Ажилласан техник /ш/ | Ажилласан хүн /ш/ | Ажилласан хоног | Техниктэй холбоотой нийт зардал, төг | Цалингийн зардал, төг | Бусад зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Инфинити | Ажиллах хүч | | **6** | **23** | | 9,358,572 | 935,857 | **10,294,429** |
| | Экскаватор | 5 | 12 | 23 | 117,076,140 | 12,912,722 | 12,998,886 | **142,987,748** |
| | Бульдозерь | 2 | 4 | 5 | 10,465,821 | 1,022,001 | 1,148,782 | **12,636,604** |
| | Автосамосвал | 15 | 26 | 19 | 86,230,588 | 5,618,510 | 9,184,910 | **101,034,008** |
| | Ачигч | 2 | 5 | 13 | 10,016,918 | 1,157,108 | 1,117,403 | **12,291,429** |
| **Нийт** | | **24** | **53** | **23** | **223,789,467** | **30,068,913** | **25,385,838** | **279,244,218** |
| **1 га газар нөхөн сэргээх өртөг** | | | | | **35,522,138** | **4,772,843** | **4,029,498** | **44,324,479** |
| **1м3 үүлын ажлыг нөөгдөх өртөг** | | | | | **3,503** | **471** | **397** | **4,371** |

## 3.2 БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ – 6.4 га

2023 онд хийгдсэн техникийн нөхөн сэргээлтийн үе шат бүрэн дуусч талбайн хөрс чулуулаг тогтворжиж, нягтаршсаны дараа 2024 онд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг 6,4 га талбай дээр MNS 5918:2023 "Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага" стандартыг мөрдлөг болгон хийж гүйцэтгэсэн. Голын хамгаалалтын бүст тарихад тохиромжтой мод болох бургасыг байгалийн бүс бүслүүр харгалзахгүйгээр эгнээ хооронд 2м зайтай, 1 га талбайд 2500ш ногдож байхаар тооцож 6,4 га талбайд 16000 ш бургас тарьсан. Тарилтыг хаврын улиралд 4 сарын 21 - 5сарын 3-ны хооронд 14 хоногийн хугацаанд хийж 22 хүн 16000 ш бургас тарьсан. Хандгайт уурхай нь биологийн нөхөн сэргээлтийг дотоод техник, боловсон хүчнээр нийт 36,798,543 мянган төгрөгийн зардалтайгаар хийж гүйцэтгэсэн.

*Зураг 3.4: Биологийн нөхөн сэргээлт хийгдэж байгаа нь талбайн дэвсгэр зураг*










*Зураг 3.5: Биологийн нөхөн сэргээлт хийгдсэний дараа*








*Хүснэгт 9: Биологийн нөхөн сэргээлтийн зардлын задаргаа*

Хүснэгт 1. Цалингийн зардал

| Төрөл | Ажилласан хүн | Ажилласан хоног | Цалингийн зардал, төг | Бусад зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| Ажилтан | 22 | 14 | 18,907,766 | 1,890,777 | 20,798,543 |

| № | Тарьсан мод | Тарьсан хэмжээ,ш | Нэгжийн үнэ,төг | Нийт үнэ,төг |
|---|---|---|---|---|
| 1 | Бургас | 16,000 | 1,000 | 16,000,000 |

| | |
|---|---|
| **НИЙТ ЗАРДЛЫН ДҮН,ТӨГРӨГ** | **36,798,543** |

## 3.3 БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ ШИМТ ХӨРСИЙГ УРГАМАЛЖУУЛАХ – 3,5 га

Хандгайт уурхай нь шимт хөрсний №1-р овоолгыг салхинд хийсэх, хур борооны усанд урсах, элэгдэхээс сэргийлэн, хөрсний шимт чанарыг нэмэгдүүлэх зорилгоор ‘’Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага ‘’ MNS 5918: 2023 стандартыг баримтлан олон наст ургамлын үрээр ургамалжуулан биологийн нөхөн сэргээлт хийсэн. Нөхөн сэргээлтийн үндсэн тарималд орон нутгын ургамлыг сонгохын зэрэгцээ ургах эрчим сайтай үрийн нөөц арвинтай ургамлыг сонгох нь илүү тохиромжтой тул саман ерхөг, соргүй согооворыг сонгон тариалсан. Эдгээр ургамал нь бэлчээрийн олон наст, тэжээлийн үнэт ургамал нөхөн сэргээлтэнд өргөн ашиглагддаг үет ургамал. Үрийн норм 1га талбайд дунджаар 65кг үр байхаар тооцож үрийг 1:1 харьцаагаар хольж гар аргаар тариалсан. 8 хүн 4 өдрийн хугацаанд 227кг үрийг цацах тармуурдах ажлыг хийж гүйцэтгэсэн. Биологийн нөхөн сэргээлтийн зардлыг ҮАЗ-д тусгав.

*Зураг 3.7: Шимт хөрсний овоолгын үр цацаж ургамалжуулах ажлын явц*



*Зураг 3.8 Ерхөг согооврын үрээ 1:1 харьцаатай хольж тариалж байгаа нь*



*Хүснэгт 10. Ургамалжуулсан зардлыг ҮАЗ тусгав.*

Хүснэгт 1. Цалингийн зардал

| № | Ажилласан хүн, ш | 1 хүний ажилласан цаг | Нийт ажилласан цаг | Нийт ажилласан өдөр | Нийт цалингийн зардал |
|---|---|---|---|---|---|
| 1 | 8 | 11 | 371 | 4 | 4,941,990 |

Хүснэгт 2. Цацсан үрийн зардал

| № | Цацсан үрийн хэмжээ, кг | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|
| 1 | 227 | 35,000 | 7,945,000 |

| | |
|---|---|
| **НИЙТ ЗАРДЛЫН ДҮН** | **12,886,990** |

*Зураг 3.9 Ургамалжуулалт хийгдсэний дараах болон газарзүйн байршилын зураг*



## БҮЛЭГ ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хандгайт уурхай нь биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, амьтдын амьдрах орчныг сайжруулах, амьдрах таатай орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд 3 га талбайд ойжуулалт, уул уурхайн үйл ажиллагаагар эвдэрч орхигдсон 7 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг тус тус хийж нийт 10 га талбайд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хийж гүйцэтгэсэн.

*Хүснэгт -11*

| № | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний гүйцэтгэл | Ажлын хэмжээ | Төлөвлөгөө /сая.төг/ | Гүйцэтгэл /сая.төг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант 3-р баг Их өлөнт нэртэй газарт байрлах эвдрэлд орсон 7 га талбайд MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийж, Хандгайт уурхайн бүст байрлах 3 га талбайд биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалалтаар ойжуулалтын ажил тус тус хийж гүйцэтгэсэн. | 10 га | 10,000.0 | 154.000.0 |
| 2 | Бэлчээрийн менежментийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд Хандгайтын зуслангийн айлуудын ойр орчимд 2 цэгт ургамлын бичиглэлийг хийж гүйцэтгэсэн. | 2 цэгт | - | ҮАЗ |
| | **Нийт** | | **10.000.0** | **154.000.0** |

### **4.1** ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ

Хандгайт уурхай нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант 3-р баг Их өлөнт нэртэй газарт байрлах эвдрэлд орсон 7 га талбайд MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг Газрын хэвлийн нөхөн сэргээлтийн эрх бүхий ‘’Беверли Дилин’’ ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлэн гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгсөн. Хандгайт уурхайн бүст байрлах 3 га талбайд биологийн олон

янз байдлын дүйцүүлэн хамгаалалтаар ойжуулалтын ажил тус тус хийж гүйцэтгэсэн. Ойжуулалтыг Хандгайт уурхайн ажилтанууд, БОХ-н ажилтанууд хамтарч 2 настай нарсны тарьцаар шан хоорондоо 4м, мод хооронд 2м зайтай 3000ш нарс царилдаж тарьсан. Тарилтыг намрын мод тарих өдөр 2024.10.15-20-ны хугацаанд хийж гүйцэтгэсэн. Мөн ойжуулалт хийгдсэн талбайн тарьцын ургалтыг дэмжин, мал орохоос сэргийлж хашуужуулсан.

*Зураг 4.1: 3 га талбайн тарилт хийгдэж байх явцын зураг*







*Зураг 4.2: Ойжуулалт хийгдсэн талбайн дэвсгэр зураг, сансарын зураг*






*Хүснэгт 4.3: Ойжуулалт хийсэн талбайг мал орохоос сэргийлж хашаажуулах явц*








*Зураг 4.4: Техникийн нөхөн сэргээлт хийх гэрээ болон байршлын зураг*


ЗАХИАЛАГЧ: ГҮЙЦЭТГЭГЧ:

ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ ГЭРЭЭ

1. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ




*Зураг 4.5: Техникийн нөхөн сэргээлт хийгдсэний дараах зураг*




*Зураг 4.6: Техникийн нөхөн сэргээлт хийгдэхээс өмнөх зураг*







## 4.2 БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Бэлчээрийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд Хандгайт айлуудын зуслан орчимд бэлчээрийн талхагдалд орсон газраас 2 дээж талбай сонгон ургамлын бичиглэл хийж дүгнэлт гаргасан. Цаашид бэлчээрийг хамгаалах бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллана.

**Ургамлын бичиглэл: Дээж талбай №1 Метадата**

- **Солбицол:** 49.73485N 107.08934E
- **Газрын нэр:** Хандгайт
- **Газрын хэв шинж:** Уулын дунд ойт хээрийн зах голын нуга
- **Ургамлан бүлгэмдлийн одоогийн ашиглалт:** Бэлчээрийн талбай бөгөөд бүлгэмдэлд нутгийн айлуудын намаржаа, хаваржаа, зуслан байрлах бөгөөд бараг жилийн дөрвөн улирлын туршид тогтмол мал бэлчээрлэдэг, ашиглалт ихтэй газар
- **Мал амьтны нөлөө:** Мал ихтэй бод мал голдуу бэлчээрлэнэ.

**Байршил:** Хандгайтын айлуудын зуслан голын эргээс 450м зайтай хөндий газар
**Координат** /49,73485N 107,08934E/
**Газрын хэв шинж:** Уулын тал хээр хөндий, голын нуга татам бүхий хөндий
**Ургамлын бүлгэмдэл:** Улалж-жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст хялганат, ургамлын бүрхэц 80%

*Хүснэгт* - 12

| № | **Зүйлийн бүрэлдэхүүн** | **Тусгаг бүрхэц %** | **Ургамлын өндөр /см/** | **Зүйлийн овог** | **Ургамлын статус** | **Нас** | **Ач холбогдол** |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ширэг улалж Carex diriuscula | 80 | 10 | Улалж | Элбэг | Олон наст | Бэлчээр тэжээлийн |
| | Монгол хялгана Stipa mongolorum | 45 | 8 | Үетэн | Элбэг | Олон наст өвс | Бэлчээрийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Навтгар 5 салаа Plantago depressa | 50 | 5 | Таван салааны | Ховор | Олон наст өвс | Эмийн |
| 3 | Нугын шимтэглээ Geranium pratense | 30 | 3 | Буурцагтан | Элбэг | Олон наст | Мал дунд иддэг |
| 4 | Галуун гичгэнэ Potentilla anserina | 60 | 6 | Сарнайн | Элбэг | Олонн аст | Эмийн |
| 5 | Имт гичгэнэ Potentilla birfurca | 45 | 8 | Сарнайн | Элбэг | Олон наст | Бэлчээр,цайны ургамал |
| 6 | Их 5 салаа Plantago major | 12 | 6 | 5 салааны | Элбэг | Олон наст | Эмийн |

Ойр орчим дахь 1м радиус доторх ургамлууд

1. Азийн төлөгч өвс /цэцэгтэй/
2. Согоовор - Bromus inermis
3. Царсан гүүн хөх / цэцэгтэй/ - Scutellaria scordifolia
4. Цагаан мөөг
5. Нэг наст шарилж

**Ургамлын бичиглэл: Дээж талбай №2**

**Байршил**: Хандгайтын айлуудын зуслан, голын эргийн ойролцоо усны мониторингийн цэгээс зүүн урагш 150м

**Координат**: 49,73999/ 107,08266

**Газрын хэв шинж** : Уулын тал хээр хөндий голын татмын нуга

**Ургамлын бүлгэмдэл:** Улалж-дэгнүүлт үетэн/ алаг өвст хялганат бүрхэц 80-85%

*Хүснэгт - 11*

| № | Зүйлийн бүрдэл латин /Монгол/ | Тусгаг бүрхэц /%/ | Ургамлын өндөр /см/ | Зүйлийн овог | Ургамлын статус | Нас | Ач холбогдол |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Галуун гичгэнэ Potentilla anserina | 68% | 7 | Сарнайн | Элбэг | Олон наст | Эмийн ба балт |
| 2 | Ишгүй гичгэнэ Potentilla acaulis | 80% | 7 | Сарнайн | Элбэг | Олон наст өвслөг | Мал дунд зэрэг иддэг |
| 3 | Хиаг Elymus repens | 70% | 18 | Үетэн | Элбэг | Олон наст өвс | Бэлчээрийн |
| 4 | Ширэг улалж Carex duriuscula | 85% | 7 | Улалж | Элбэг | Олон наст өвслөг | Мал сайн иддэг |
| 5 | Сайрын хялгана Stipa glareosa | 80% | 9 | Үетэн | Элбэг | Олон наст өвс | Бэлчээрийн |
| 6 | 5 салаа Plantago major | 45% | 6 | Таван салаатны | Элбэг | Олон наст өвс | Эмийн |
| 7 | Азийн төлөгч өвс Achllea asiatica | 29% | 7 | Гол гэсэртэн | Ховор | Олон наст өвслөг | Эмийн болон балт |
| 8 | Багалбар сонгино Allium polyrrhizum | 30% | 8 | Сараана | Хүнсний | Олон наст өвслөг | Идэмж тодоройгүй |
| 9 | Энгийн буржгар Thalictrum simplex | 18% | 5 | Холтсон цэцэгт овог | Элбэг | Олон наст өвс | Эмийн болон балт |

**Дүгнэлт:** Хандгайтын бэлчээрийн талбай, айлуудын зуслангийн газар орчимд 2 дээж талбайд зүйлийн бүрэлдэхүүн, тусгаг бүрхэц, ургамлын өндөр, ургамлын статус, ач холбогдлыг тодорхойлсон. Хандгайтын айлуудын зуслангийн газарт ургамлын зүйлийн бүрдэл 6-12, өндөр 5-10см тачир ургалттай, малын бэлчээрийн даац болон айлуудын тоо, малын тоо толгой ихтэй байгааг илтгэж байна. Ургамал ид ургалт, өсөлт, үрлэлтийн үед мал идэж ургамал ургах, үрлэх нөхцөл бүрдэхгүй байгаа нь цаашдаа тухайн газар нутагт хөрсний доройтол цөлжилт үүсэх эрсдэлтэй. Тиймээс бэлчээрийн нөхөн төлжих 5-6 сард бэлчээрийг сэлгэж, өнжөөх хэрэгтэй. Энд зохилох ширэг улалж нь экологи эдийн засгийн ач холбогдол ихтэй ургамал юм. Малд сайн идэмжтэйгээс гадна суурин газрыг зvлэгжvvлэхэд ашигладаг онцлогтой. Ширэг улалж цэцэглэлтийн үе шатандаа уургийн агууламж хамгийн өндөр байдаг бөгөөд бэлчээрийн доройтлыг илэрхийлэх гол ургамал юм. Бэлчээрийн доройтлын сүүлийн үе шатанд ч тэсэж үлддэг чадвартай.

Эх сурвалж: УЦУОШГ-ын цахим хуудас, Монгол орны малын тэжээлийн ургамал, 2003, С.Жигжидсүрэн, Д.А.Жонсон

*Зураг – 4.7 Хандгайт зуслангийн айлуудын орчимд хийсэн бичиглэл, байршил*








## БҮЛЭГ ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ

Төсөл хэрэгжих 2024 онд MV- 016947, MV-022128 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд нүүлгэн шилжүүлэх шаардлагатай асуудал гараагүй. Цаашид нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал тулгарвал арга хэмжээг төлөвлөн авч хэрэгжүүлнэ.

## БҮЛЭГ ЗУРГАА. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

‘’ИНФИНИТИ СПЭЙС’’ ХХК-н Хандгайт уурхай нь Ерөө сумын түүхт 100 жилийн ойг тохиолдуулан ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад түүх, соёлын өв уламжлалаа хадгалах, байгаль орчноо хайрлан хамгаалах үзэл төлөвшүүлэх зорилгоор **“Бидний бахархалт-Ерөө нутаг”** сэдэвт гар зургийн уралдаан зохион байгуулсан. Нийт 157 бүтээл

ирүүлсэнээс 3 насны ангилалаар 9 бүтээл шалгаруулан 1.800.000 мянган төгрөгөөр шагнаж урамшуулсан. Шагналыг сумын түүхт 100 жилийн ойгоор гардуулан ирсэн нийт бүтээлүүдээр зургийн үзэсгэлэн гаргасан.

*Хүснэгт -12 Соёлын биет бус өвийг хамгаалах ажлын задаргаа*

| № | Авсан арга хэмжээ | Ажлын хэмжээ | Төлөвлөгөө /мян.төг/ | Гүйцэтгэл /мян.төг/ |
|---|---|---|---|---|
| 1. | Соёлын биет бус өвийг сурталчлах, хамгаалах зорилгоор гар зургийн уралдааныг Ерөө сумын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан. | 157 бүтээл | 2000.0 | 1800.0 |
